



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/10

Даланзадгад

Г Эрүүл мэндийн байгууллагуудыг өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2 дахь заалт, Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/93 дүгээр тушаал, 19 дүгээр албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2020 оны A/88, A/101, A/146 дугаар захирамжууд, 01 албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудыг Коронавируст халдвартын (Covid-19) болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны 02 дүгээр сарын 17-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, Эрүүл мэндийн газарт мэргэжлийн ангийн түр штабыг байгуулсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед түр штабыг өдөр тутмын удирдлагаар хангаж, халдвартын болзошгүй тохиолдлын үеийн хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангах нөөцүүдийг бүрдүүлж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга /М.Цэндсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн төлөвлөгөөндөө тодотгол хийж, бэлэн байдлыг шуурхай хангаж, эмч мэргэжилтнүүдэд эмнэл зүйн сургалтыг шуурхай зохион байгуулж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга наарт үүрэг болгосугай.

4. Эмнэл зүйн мэргэжлийн зөвлөх багийн үйл ажиллагааг идэвхжүүлж, шинэ коронавирусийн болзошгүй тохиолдолд үзүүлэх эмнэл зүйн тусlamжийг чадавхжуулах мэргэжил, арга зүйн дэмжлэгт арга хэмжээг идэвхтэй зохион байгуулж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал бөгөөд эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангийн дарга /Я.Болдбаатар/-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээ, мэдээллийн шуурхай оновчтой тогтолцоог бүрдүүлэн ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга /Б.Мидэрсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ